



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 6 сарын 15 өдөр


Дугаар 139

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.
3. Эрхлэх чиг үүргийнхээ хүрээнд уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг салбарын төрийн байгууллагууд болон төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч мэргэжлийн төрийн бус байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.
4. Уг журам батлагдсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 66 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.



Б.МӨНХБААТАР

151030452

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 6 дугаар сарын 15 өдрийн
139 дугаар тушаалын хавсралт

**БАРИЛГЫН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭН БОЛОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ШИНЭЧЛЭХ, МЭДЭЭЛЛИЙГ МЭДЭЭЛЛИЙН САНД
БАЙРШУУЛАХ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн санг хөтлөх, шинэчлэх, ашиглах, хадгалах, хамгаалах, лавлагаа, мэдээллээр хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлал, мэдээллээр ил тод хангахтай холбоотой үйл ажиллагаанд салбарын болон мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгоно.
- 1.3. Мэдээллийн сангийн эзэмшигч нь барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “яам” гэх/ байх бөгөөд мэдээллийн сангийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавина.
- 1.4. Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийн санд байршуулах, хадгалах, хамгаалах, иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд:
 - 2.1.1. “мэдээллийн сан” гэж барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн иж бүрдлийг;
 - 2.1.2. “мэдээллийн сангийн цахим систем” гэж барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн вэбэд суурилсан програм хангамжийг;
 - 2.1.3. “лавлагаа” гэж мэдээллийн санд үндэслэн гаргасан барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн болон салбарын мэргэжилтний бүртгэл мэдээллийн үнэн зөв гэдгийг нотолсон баримт бичгийг;
 - 2.1.4. “мэдээлэл” гэж мэдээллийн санд бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн талаарх цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг;
 - 2.1.5. “админ” гэж яамны мэдээллийн сан, системийн асуудал хариуцсан албан хаагчийг;

2.1.6. “үндсэн хэрэглэгч” гэж яам болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын албан тушаалтныг;

2.1.7. “тусгай хэрэглэгч” гэж хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд хамтран ажиллагч төрийн бусад байгууллагуудын албан хаагчдыг;

2.1.8. “энгийн хэрэглэгч” гэж тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн ажилтнуудыг.

Гурав. Мэдээллийн сангийн бүтэц, зохион байгуулалт

3.1. Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн цахим систем нь дараах мэдээллийн сангаас бүрдэнэ. Үүнд:

3.1.1. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийн сан /хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт завсар үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд/;

3.1.2. барилгын салбарын мэргэжилтэн /инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчин, мэргэшлийн зэрэгтэй инженер, архитектор, төсөвчин, бусад инженер техникийн ажилтан/-ий мэдээллийн сан.

3.2. Энэхүү журмын 2.1.2-т заасан мэдээллийн сангийн цахим систем нь 3.1.1-д заасан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах, олгох, бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, нөхөн олгох, хүчингүй болгох, хяналт тавих, 3.1.2-т заасан барилгын салбарын мэргэжилтний мэдээллийг хөтлөх, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн лавлагаа мэдээллээр хангах үйл ажиллагааг эрхэлнэ.

3.3. Мэдээллийн сангийн цахим систем нь төрийн мэдээлэл солилцооны систем /ХУР/, танилт нэвтрэлтийн систем /ДАН/ болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын мэдээллийн сантай мэдээлэл солилцох боломжтой байна.

Дөрөв. Мэдээллийн санг ашиглах, шинэчлэх хадгалах, хамгаалах

4.1. Энэхүү журмын 2.1.1-д заасан мэдээллийн сан нь Барилгын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үндсэн сервер, нөөц сервер нь Үндэсний дата төв дээр байрлана.

4.2. Мэдээллийн системийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн санг серверт суулгах, тохируулах асуудлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж ханган ажиллана.

4.3. Мэдээллийн сангийн үндсэн сервер дээр өгөгдөл, мэдээлэл нэгтгэгдэж, салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

4.4. Мэдээллийн сангийн цахим системийн мэдээлэлд орсон нэмэлт, өөрчлөлтүүд тухай бүр шинэчлэгдэнэ.

4.5. Нэгдсэн мэдээллийн сангаар дамжуулан лавлагаа, мэдээллээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үйлчилнэ.

4.6. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаатай холбоотой нээлттэй мэдээллийг мэдээллийн сангийн цахим системд байршуулна.

4.7. Нээлттэй мэдээлэл гэдэгт байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой мэдээллээс бусад мэдээллийг ойлгоно.

4.8. Нээлттэй мэдээллийг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага цахим хэлбэрээр үзэж, ашиглаж болно.

4.9. Мэдээллийн сангийн цахим системээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлтэй хуулийн этгээд эсэх талаар тухайн бүртгэлд хамаарал бүхий иргэн, хуулийн этгээд QR кодоор баталгаажсан цахим лавлагааг авч болох бөгөөд лавлагаа нь бичигдсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

4.10. Мэдээллийн сангийн цахим системд хандах хэрэглэгч нь дараах төрөлтэй байна. Үүнд:

4.10.1. админ;

4.10.2. үндсэн хэрэглэгч;

4.10.3. тусгай хэрэглэгч;

4.10.4. энгийн хэрэглэгч.

4.11. Админы эрхийг яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар цахим бодлого, мэдээллийн систем хариуцсан албан тушаалтанд олгоно.

4.12. Админ нь мэдээллийн сангийн цахим системд хандах үндсэн болон тусгай хэрэглэгчийн эрхийг нээх, цуцлах, өөрчлөх, сэргээх хүсэлтийг уг системээр дамжуулан хүлээн авч, олгоно.

4.13. Админ нь үндсэн болон тусгай хэрэглэгчийн эрхийг тухайн албан тушаалд томилогдсон болон чөлөөлөгдсөн тушаал, нууцын баталгааг үндэслэн яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр олгож, өөрчилж, цуцална.

4.14. Мэдээллийн сангийн цахим системд хандалт болон энэхүү журмын 3.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан түүх /log file/ автоматаар тухай бүр хадгалагдана.

4.15. Системд нэвтрэх эрх бүхий албан хаагч нь нууц үгийн нууцлал, хамгаалалтыг өөрөө хариуцна.

4.16. Мэдээллийн санд дараах үйлдлүүдийг бүх хэрэглэгч хийхийг хориглоно. Үүнд:

4.16.1. Мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, устгах, хуулбарлах;

- 4.16.2. Мэдээллийн сангийн програм хангамжийг өөрчлөх, устгах, эвдэх;
- 4.16.3. Мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай үйл ажиллагааг санаатай болон санамсаргүй байдлаар алдагдуулах, эвдэх, гэмтээх;
- 4.16.4. Мэдээллийн санд хортой код тараах;
- 4.16.5. Мэдээллийн санд агуулагдаж байгаа хуулийн этгээд, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;
- 4.16.6. Мэдээллийн сангаас авсан мэдээллийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах;
- 4.16.7. Мэдээллийн санд хандах эрхийг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах;
- 4.16.8. Мэдээллийн сангийн ажилтан хуулиар хүлээсэн давуу эрхээ ашиглан сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг алдагдуулах.

Тав. Хариуцлага

5.1. Мэдээллийн санг ашиглах явцад мэдээлэл энэхүү журмын 4.16 дахь хэсэгт заасныг зөрчсөн нөхцөл байдал үүсэхэд буруутай этгээд нь Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль болон мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлагыг бүрэн хүлээнэ.

--o0o--